

МАНЛАЙЛАГЧ АЖ АХУЙ БОЛ МОНГОЛЫН БЭЛЧЭЭРИЙН МАЛ АЖ АХУЙН ХӨГЖЛИЙН НЭГ АРГА ЗАМ БОЛНО

Монгол судлаач БААТАР

Агуулгын товч: Бэлчээрийн мал аж ахуйн үйлдвэрлэлийн явцад зарим нэг аж ахуйн нэгжүүд зах зээлээ өргөтгөх, ашиг орлогоо нэмэгдүүлэх, мэргэжлийн судалгаа хийх чадвартай, мал аж ахуйн хөгжилтөд урагшлуулах нөлөө үзүүлж чаддаг. Ийм аж ахуйн нэгжийг манлайлагч аж ахуй гэнэ. Манлайлагч аж ахуйн олон зүйлийн хэлбэр байдаг. Хувийн, орон нутгийн, хамтарсан, улсаас төлөвлөгөөтэй байгуулсан аж ахуйн нэгж зэрэг ...

Манлайлагч аж ахуй бол Монгол улсын бэлчээрийн мал аж ахуйг хөгжүүлэх нэг арга зам, хувийн аж ахуй ба нийгмийн зах зээлийн хоорондох холбоос мөн. Манлайлагч аж ахуй бол мал аж ахуйн үр ашгийг дээшлүүлж, малчдын орлогыг нэмэгдүүлэх гол хүчин зүй зохистой үр ашгийн тогтолцоог буй болгох үндэс суурь, мал аж ахуйн үйлдвэрлэлийн шинжлэх ухаан техникийн болон үйлдвэрлэлийн хүчин чадлыг дээшлүүлэх хөшүүрэг мөн.

Х Х Х

Монгол улс бол дэлхийн бэлчээрийн мал аж ахуйн томоохон орон мөн. Мал аж ахуй нь Монгол улсын улс ардын аж ахуйн суурь мөн бөгөөд малын ашиг шимийн орлого нь улс ардын аж ахуйн орлогын дийлэнхи хэсгийг эзэлнэ. Гэвч Монгол улс мал аж ахуйн талаар дэлхийн хүчирхэг улсын эгнээнд орж чадаагүй байна. Байгалийн баялгаа эзэмшиж ашигласнаар шинжлэх ухааны үндэслэлгүй, удирдлага замбараагүй, боловсруулах арга хэмжээ нь хоцрогдонгуй, мал аж ахуйн салбар дахь шинжлэх ухаан техникийн хэрэгжилт нь 30 хувьд хүрэхгүй байгаа зэрэг олон шалтгаанаас хамаарч, мал аж ахуй хөгжсөн бусад орноос хол хоцорч байгаа юм. Иймээс Монгол улс нь мал аж ахуйн томоохон орноос мал аж ахуйн хүчирхэг орон больё гэвэл мал аж ахуйн үйлдвэрлэлийн хурдцаа түргэтгэж, шинжлэх ухаан техникийн өлөлтыг сайтар ашиглаж хэд хэдэн бүлэг манлайлагч аж ахуйг буй болгон, зах зээл ба мал аж ахуйн үйлдвэрлэлийн хэлхээ холбоог эрчимжүүлэх нь зүйтэй.

Манлайлагч аж ахуйн нь Монгол улсын мал аж ахуйн хөгжил, мал аж ахуйн тааварчлал, төрөлжүүлэлт, нийгэмчлэл, шинэчлэлтийг ахиулахад чухал ач холбогдолтой юм.

Нэг. Манлайлагч аж ахуй бол мал аж ахуй эрхлэлт болон нийгмийн зах зээлийн хоорондох холбоос мөн.

Монгол улсад малын ашиг шимийг боловсруулах аж ахуйн нэгж 200 гаруй байгаа боловч олонхи нь хүчин чадлаар сул, техник мэргэжил, тоног төхөөрөмж хоцрогдонгуй, мөн орон зайн тохируулалт нь зохисгүй, удирдлага нь сул учраас анхдагч боловсруулсан бүтээгдэхүүнээ хэрэглэхгүй сул хаяхад хүрч, бүрэн боловсруулах хүчин чадал сул дорой байгаа нь мэдэгдэж байна. Эдүгээ хэдийгээр “Буян”, “Говь” зэрэг аж ахуйн нэгж буй болж, хөгжиж байгаа боловч, тэдгээр нь мөн манлайлагч аж ахуй болж чадаагүй байна. Нэн ялангуяа малчид нь малын ашиг шимээ зах зээлд солилцох тухайд гэвэл их хотын аж үйлдвэрлэлийн компаниуд шиг мэдээлэл ашиглаж, зах зээлийн хэрэгцээг зөвөөр магадлаж чадахгүй байдаг тул шуурхай бодлогыг тогтоож чаддаггүй. Энэхүү сул тал нь аж ахуй эрхлэлтэнд нүдэн балай хандахад хүргэдэг. Иймээс энэхүү бэрхшээлийг шийдвэрлэхэд манлайлагч аж ахуйг зах зээлийн харилцаанд оруулах ёстой. Нэг талаар мэдээлэл цуглуулан, зах зээлийн байдлыг судалж, малчдадыг зах зээлд залж жолоодох арга хэмжээ авна. Нөгөө талаар нэг хэсэг дунд, бага хэлбэрийн аж ахуйн нэгжийг төрөлжсөн, нэгтгэсэн хөгжлийн замд оруулж, тэднийг дэлхийн зах зээлд чиглэсэн манлайлагч аж ахуй болгохоор төр засгаас урамшуулан дэмжих хэрэгтэй.

Хоёр. Манлайлагч аж ахуй бол мал аж ахуйн үр ашгийг дээшлүүлж малчдын орлогыг нэмэгдүүлэх хөдөлгөх хүч мөн.

Манлайлагч аж ахуй нь зөвхөн анхдагч бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг мал аж ахуйн үйлдвэрлэлийг дахин нарийн боловсруулах, солилцооны хүрээнд хөтлөн оруулах чадвартай байдаг.

Зах зээл ба нийгмийн хөгжилтийг дагалдан хүмүүсийн мал аж ахуйн бүтээгдэхүүний хэрэгцээ улам нэмэгдэж, анхдагч бүтээгдэхүүнийг шаардаж байснаасаа улмаар янз бүрийн нарийн боловсруулсан бүтээгдэхүүнийг шаардах болжээ. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн эцсийн боловсруулалт, хадгалалт, сав, баглаа, тээвэрлэх борлуулах зэрэг ажлын хуваарьт гарсан өртөг, үр ашгийн хэмжээ нь ч өдөр ирэхүйе нэмэгдэж, зарим нь анхдагч бүтээгдэхүүний өртгөөс хэд дахин, цаашилбал хэдэн арав дахинаар өсчээ. Мал аж ахуйн хөгжлийн зорилт гэвэл даруй энэ хандлагад тохируулан, мал аж ахуйн зөвхөн түүхий эд, анхдагч бүтээгдэхүүний орлого нь мал аж ахуйн зөвхөн түүхий эд, анхдагч бүтээгдэхүүний орлого нь маш бага байдлыг өөрчилж малчдын боловсруулах ба солилцооны орлогыг нэмэгдүүлэх явдал юм. Энэ нь голдуу боловсруулах ба солилцооноор гол цогц болгосон манлайлагч аж ахуйгаар дамжин биелэнэ.

Гурав. Манлайлагч аж ахуй бол зүй зохистой үр ашгийн тогтолцоог байгуулахын үндэс суурь мөн.

Манлайлагч аж ахуй бол мал аж ахуйн үйлдвэрлэлийн хөгжил, аж ахуй ба малчид “Хамтаар ашиг олж, хамтаараа хариуцлага үүрэх” бөгөөд давуу талаа ахиулж, харилцан дээшлүүлэх тогтолцоог бий болгохын үндэс суурь бөгөөд аж үйлдвэрлэлийн дотоод хөдөлгөгч хүч, түүний хөгжлийн баталгаа болох юм. Мал аж ахуй тогтвортой хөгжиж чадах эсэхийн чухал

нэгэн нөхцөл бол даруй боловсруулалт, солилцоог эрхлэж байгаа аж ахуй ба малчдын харилцаа жич тэдний чадавхи, давуу тал нь харилцан адилгүй ч хоорондоо салшгүй харилцаатай байх явдал болно. Саланги давуу талаа нийлүүлэн, харилцан уялдуулж аж үйлдвэрлэлийг илүүтэй хөгжүүлсе гэвэл тэдний хооронд аж ахуйн ашиг тус бүхий нэгдмэл цогцолбор байгуулах хэрэгтэй. Аж ахуйн нэгж ба малчид “Хамтаар ашиг олж, хамтаар хариуцлага үүрэх” харьцааг бий болгож чадах эсэх талаар малчид өөр өөр үзэл бодолтой байдаг болохоор манлайлагч аж ахуйгаас сул дорхой юм. Иймээс гол хариуцлагыг манлайлагч аж ахуй үүрвэл зохино. Манлайлагч аж ахуй нь олохоосоо урьдаар өгөх зарчмыг баримталж, үйлдвэрлэлийн хөгжлийг ахиулж байж ашгийн төлөө ажиллавал зохино. Үйлдвэрлэлийн зардал төлөх, үйлдвэрлэлийн хэрэгслийг зээлээр худалдан төлөх, шинжлэх ухаан техникийн үйлчилгээг хангах зэрэг хэлбэрээр боловсруулах, борлуулах явц дахь ашиг орлогыг малчдад хамтад нь олгож өгвөл сая түүхий эдийн суурин газрын тогтвортой байхыг хангаж чадна. Үүний дагуу манлайлагч аж ахуй нь даатгалын суурь мөнгийг гаргаж, гай гамшиг болох буюу зах зээл тогтворгүй болбол малчдын ашиг тусыг хамгаалдаг байх хэрэгтэй. Нэг үгээр хэлбэл, олон зүйлийн арга хэмжээ авч, эдийн засгийн эзэгнэлтийн амлах хүчнийг буй болгох хэрэгтэй.

Дөрөв. Манлайлагч аж ахуй бол мал аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухаан техникийн ололтыг өргөн нэвтрүүлэх, улсын үйлдвэрлэх хүчний хэмжээг дээшлүүлэх дагуулагч хүч мөн.

Шинжлэх ухаан техникийн дэвшлийг ашиглаж, ашиг орлогоо нэмэгдүүлье гэвэл олон талын арга хэмжээг авч хөдөлмөрчдийн амьдрал ахуйг дээшлүүлэх хэрэгтэй. Манлайлагч аж ахуй нь нэг талаар дэвшилт мэргэжлийг нэвтрүүлж, малын үүлдрийг сайжруулан, нөгөө талаар малын анхдагч бүтээгдэхүүний боловсруулалт, шинээр савлах, хадгалах мэргэжлийг дэлхийн тэргүүний хэмжээнд хүргэх буюу ойртуулах хэрэгтэй. Иймээс шинжлэх ухаан техникээр түшиг болгож, зах зээлийн харилцааг гол болгон, ашигт малтмалаа ашиглан бүх улсынхаа хэмжээнд орон нутгийн онцлогт зохицсон, саалийн үнээ, идэшний үхэр, хонь, ямаа, ноолуурын ямаа, арьс шир боловсруулах зэрэг... тухайлсан аж ахуйг хөгжүүлсэн, дээд зэргийн мэргэжил, технологийг ашигласан, дээд зэргийн хавсаргасан өртөг, дээд зэргийн өргөн зах зээл бүхий манлайлагч аж ахуйг буй болговол, Монгол улсын мал аж ахуйг нэгдмэл, цогцолбороор шинэ шатанд гаргаж, Монгол улсын мал аж ахуй улам сайн хөгжихөд нэн их хувь нэмэр оруулж, Монгол улсын мал аж ахуй дэлхийн зах зээлтэй нэн сайн ойртож чадна.

Хятад хэлнээс орчуулсан Л.Бэгзжав